

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХТУХАЙ

1 дүгээр зүйл. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах өвс, бүх төрлийн малын тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг тус тус импортлоход гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн албан татвараас чөлөөлөх бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос, өвс, бүх төрлийн малын тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

Гарын үсэг